

ИРГЭНИЙ ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛ

Хичээл-1 Арга гэж юу вэ?

Арга гэдэг нь мэдлэгийг зөв тийш залдаг ухаан. Аливаа үйл хэргийг бүтээхдээ амьтан бүхнийг зовлон бүхнээс нь гэтэлгэж өгье гэсэн энэрэхүйн нинжин сэтгэл, бусдыг зөрчил хямралаас хагацуулж, гэм бүглийг засья гэх нигүүлсэнгүй сэтгэлээр хандах нь хамгийн зөв арга болно. Ямар ч ажил үүргийг гүйцэтгэхдээ хүн төрөлхтний тусын тулд, бусдад тустай, улс эх орондоо хэрэгтэй үйл хэргийг сонгож, аль болох бага хүч гаргаж, богино хугацаанд өндөр чанартай үр дүнд хүрч болох арга замыг олж тогтоохыг арга эв гэнэ.

Зөв арга буюу энэрэхүй нинжин сэтгэлийг үүсгэхийн тулд эхлээд өөрийн алдаа гэмийг засах нь арга ухаан болно. Ямарваа үйл ажиллагаа явуулахдаа бусдын төлөө гэсэн зөв хандлагаар, хүчээр муйхарлан зүтгэлгүй арга эвийг олж гүйцэтгэх нь олны талархал хүлээхээс гадна, өөрт болон бусдад тустай үйл хэргийг хялбар гүйцэтгэж, зорилгодоо хүрэх ач холбогдолтой.

Аргыг дадуулсны ач тас

“Сайн үйлийг хүч чармайлт гарган хэрэгжүүлдэг, тэрхүү хүч чармайлтаа хэд дахин давтан гаргавал сайн үйл нь дадал болно. Сайхан сэтгэл гэдэг нь эрүүл бие л гэсэн үг: түүнийг эзэмдвэл үл ажиглагдам байдлаар бүх үйл хэрэг чинь амжилттай болно” *Л. Толстой*. Бусдын тусын тулд хэмээх сайхан сэтгэлээр аливаад хандах нь хамгийн зөв сэтгэл, зөв арга юм. Гагцхүү тэр зөв аргаа байнгын хүчин чармайлт гаргасны үр дүнд л өөртөө дадуулж хэвшүүлэх ажгуу. Өөрийн эзэмшсэн мэдлэгийг өөрт болон бусдад тустай болгон хувиргаж чадах нь аргыг дадуулсны ач тус юм. Аливаа ажлыг өөрийн болон бусдын тусын тулд асрах энэрэх сэтгэлийг агуулж, аль болох болох хурдан хугацаанд, хамгийн бага хүч зардал гаргаж гүйцэтгэх арга эвийг олж чаддаг байх нь ямар ч ажлаас шантрахгүй байх сэтгэлийн хүчийг өгдөг. Сэтгэл уужран тэлснээр аливаа бэрхшээлийг зовлон гэж үзэхгүй, түүнд сэтгэл торохгүй болж, сэтгэл амар амгалантай болно. Амар амгалантай сэтгэлийн үүднээс гаргасан шийдвэр зөв болж, хийж байгаа үйл, ажил хэрэг ч өөрт болон бусдад тустай болдог.